

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлБайгууллагын нэр: *Гавшгай ус ХХК*Тайлант огноо: *2017 он*

№	Сорил хийсэн дансны нэр	Аудитаар илэрсэн асуудал	Санхүүгийн тайланд үзүүлэх нөлөө (материаллаг, материаллаг бус)	Аудиторын санал (Бүртгэлийн бичилт, тооцоолол)	Тухайн байгууллагын санал (Бүртгэлийн бичилт, тооцоолол)
		ТУЗ-аар баталсан баяр ёслолын арга хэмжээний зардлын төлөвлөгөөг 6,157.9 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан	Материаллаг	Албан шаардлага	2018 онд төсөв хэтрүүлэхгүй хянаж ажиллана,
		Байгууллагын даргын тушаалаар прокурорын байгууллагын 20 жилийн ойд 50.0 мянган төгрөгийн, ТБДҮйлдвэр байгуулагдсаны 20 жилийн ойд 200.0 мянган төгрөгийн, ЕБС-д 101.5 мянган төгрөгийн зэрэг нийт 351.5 мянган төгрөгний хандив өгсөн	Материаллаг	Албан шаардлага	Төсвийн тухай хуулийн 25-дугаар зүйлийн 25,10-д Төрийн болон ОНӨмчийн хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно гэсэн заалтуудыг мөрдлөг болгон хандив тусламж өгөхийг зогсоогоод байна
		Анхан шатны баримтын бүрдэлгүй 21,953.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгасан	Материаллаг	Зөвлөмж	Баримт бүрдэлийг хууль тогтоомжинд нийцүүлэн бүрдэл болгон ажиллаж байна,
		Гүйцэтгэсэн ажлын үр дүнг албан томилолт олгосон удирдах дээд шатны байгууллага буюу албан тушаалтанд танилцуулан, томилолтын үнэмлэх дээрээ гарын үсэг зуруулж, томилолтоор ажилласан хугацааг батлуулан, хаалт хийлгээгүй буюу ажлын гүйцэтгэлийн тайлангүй, унаа байрны дэмжих баримтгүйгээр албан томилолтын зардалд 2,611.5 мянган төгрөгийг олгосон	Материаллаг	Зөвлөмж	Баримт бүрдэлийг хууль тогтоомжинд нийцүүлэн бүрдэл болгон ажиллаж байна,

	Тушаал шийдвэргүйгээр инженер Ц.Цэнддоржид 1,980.0 мянган төгрөгийн, гагнуурчин Б.Цэдэндоржид 1,304.1 мянган төгрөгийн, орлогын байцаагч П.Нэргүйд 777.7 мянган төгрөгийн ажил хавсарсаны нэмэгдлийг, жолооч Б.Ууганбаярт тушаалд заасан хэмжээнээс 630.0 мянган төгрөгөөр илүү зэрэг нийт 4,691.8 мянган төгрөгийн цалин олгосон	Материаллаг	Зөвлөмж	Баримт бүрдэлийг хууль тогтоомжинд нийцүүлэн бүрдэл болгон ажиллаж байна,	
	Санхүүгийн тайланд татварын өглөгийг 4,240.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан	Материаллаг бус	Зөвлөмж	Хуримтлагдсан алдагдал хааж бичилт хийсэн	
	Жилийн эцсийн санхүүгийн тайлангаарх орлогын албан татвараа тооцохдоо хүү торгуулийн зардал 3,633.6 мянган төгрөг, баяр ёслолын зардал 27,908.9 мянган төгрөгийг татвар ногдох орлогоос хасаж тооцсон	Материаллаг бус	Зөвлөмж	Дараа онд татварийн зөрүүгийн тайланг нөхөж татвар ногдох орлогоос хасахгүй	

Тайлбар:

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэл хөтөлсөн аудитор ..... М.Балжинням

Огноо: 2018.03.15

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг зөвшөөрсөн:

Байгууллагын дарга..... (Л.Балдорж)

Байгууллагын ня-бо .....(Ё.Батцэнгэл)

Анхан шатны хяналт хийсэн аудитын менежер: ..... Б.Батмөнх

Огноо: .....

Хоёрдах шатны хяналт хийсэн Тэргүүлэх аудитор: ..... Ч.Энхтуяа

Огноо: .....

Аудитын менежерийн санал: .....

Тэргүүлэх аудиторовын санал: .....